



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр




Соронз зарим материалаар хийгдсэн биетэд татагддаг тухай бид өмнө нь үзсэн. Тэгвэл тэрхүү шинжээс гадна түүний өөр нэгэн чухал шинж чанар байдгийг мэдэх үү?

Даалгавар

1 Доорх бичвэрийг уншаад үгсийг нөхөж бичээрэй.


Та нар дэлхийг аварга том соронз гэдгийг мэдэх үү? Хэрэв чи зурагт үзүүлсэн шиг шулуун соронзыг уяад унжуулвал нэг байрандаа зогсно. Энэ нь соронз хоорондын харилцан үйлчлэлийн үр дүн юм.
Соронзны нэг тал дэлхийн

хойд туйл руу, нөгөө тал нь өмнөд туйл руу заана. Тэгвэл бид хойд туйл руу зааж байгаа талыг соронзын [] туйл гээд [] үсгээр, харин өмнөд туйл руу зааж байгаа талыг соронзын [] туйл гээд [] үсгээр тэмдэглэдэг.




N, S, хойд, өмнөд

2 Зурагт хоёр соронзын харилцан үйлчлэлийг харуулж байна. Хэрэв утсанд зүүж унжуулсан соронз сумны чиглэлийн дагуу хөдөлж байгаа бол өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.



Соронзны эсрэг туйлууд байна.



Соронзны ижил туйлууд байна.

3 Доорх тохиолдолуудад хоёр соронз таталцах бол "ТАТ" эсвэл түлхэлцэх бол "ТҮЛХ" гэж тэмдэглээрэй.



.....

.....

.....

.....



.....

.....

.....

.....

Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:





Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр



Соронзон хоорондын таталцах, түлхэлцэх үйлчлэлийг бид өмнө нь судалсан. Тэгвэл энэ удаа бүгдээрээ соронзон туйлуудын талаар илүү ихийг судалъя. Хүүхдүүд ээ соронзон туйлуудыг салгаж болох болов уу? Зөвхөн хойд туйлтай соронз гэж байх болов уу?

Даалгавар

1 Бидэнд нэгэн шулуун соронз байсныг зурагт үзүүлснээр хоёр хэсэгт хуваасан гэж үзье. Хуваагдсан хэсгүүдийн туйлийг 1 болон 2 гэж тэмдэглэе. Зааврын дагуу ажиллаарай.



А) Хуваагдсан хэсгүүд ямар туйлтай байх вэ? Таамаглалаа бичээрэй.



Б) Цэнхэр хэсгийг өөр нэгэн шулуун соронзод үйлчлүүлжээ. Үр дүнг дүгнэж бичээрэй. Та нарын таамаглалтай нийцэж байна уу?



Хоорондоо байгаа учраас цэнхэр хэсгийн 2 гэсэн туйл нь туйл байна.



Хоорондоо байгаа учраас цэнхэр хэсгийн 1 гэсэн туйл нь туйл байна.

В) Бид цэнхэр хэсгийг ямар туйлуудтай болсныг мэдлээ. Тэгвэл цэнхэр болон улаан хэсгүүд хоорондоо хэрхэн үйлчилж байгааг дор үзүүлжээ. Үр дүнг дүгнэж бичээрэй. Та нарын таамаглалтай нийцэж байна уу?



Хоорондоо байгаа учраас улаан хэсгийн 1 гэсэн туйл нь туйл байна.



Хоорондоо байгаа учраас улаан хэсгийн 2 гэсэн туйл нь туйл байна.

Г) Дээрх туршилтаас соронзыг хуваах үеийн туйлийн өөрчлөлтийн талаар өөрсдийн дүгнэлтийг бичээрэй.

.....


.....

.....

Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Хүүхдүүд ээ, та нар хоёр төрлийн соронз байдгийг мэдэх үү? Нэг нь бидний өдөр тутамд ашигладаг луужин зэрэгт ашиглагддаг байнгын соронз. Харин нөгөөхийг түр соронз гэж нэрлэдэг. Бүгдээрээ түр соронз хийцгээе.

Даалгавар

1 Зааврын дагуу ажиллаад түр соронз хийцгээе.

Хэрэглэгдэхүүн:



1. Байнгын соронз
2. Төмөр бичгийн хавчаар
3. Төмөр хадаас

Аюулгүй ажиллагаа:

1. Соронзыг унагаж болохгүй.
2. Соронзтой ажиллах аюулгүй ажиллагааг мөрдөнө.
3. Хадаастай болгоомжтой харьцаж, өөрийгөө гэмтээхээс сэргийлж бээлий өмсөх.

Заавар:

1. Байнгын соронзыг сонгохдоо аль болох хүчтэй соронз сонгох нь чухал. Сонгосон соронзын нэг туйлаар зурагт харуулсны дагуу хадаасын голоос хадаасны тав руу чиглүүлэн үрнэ. Үүнийг хэдэн минутын турш үргэлжлүүлнэ.
2. Дараа нь соронзын нөгөө туйлаар хадаасны голоос үзүүр рүү чиглүүлэн үрнэ. Мөн үүнийг хэдэн минутын турш үргэлжлүүлнэ.
3. Хадаасыг түр соронз болсон эсэхийг түүнд төмөр бичгийн хавчаар ойртуулан шалгана.



2 Хийсэн түр соронзоо ашиглан дараах асуултад хариулаарай.

- 1) Хадаасыг соронзын туйлуудтай үйлчлүүлж үзээд соронз болсон хадаасын туйлуудыг судлаарай.

Хадаасны тав –

Хадаасний үзүүр –

- 2) Хадаас соронзон шинж чанараа хэр удаан хадгалж байна вэ?

.....

Дууссан: сар өдөр



Өөрийн үнэлгээ:

